



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 5/12

Хэрлэн сум

О.Алтантуяаг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр, 2014 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

Нэг. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй О.Алтантуяаг 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн Санхүүгийн хяналт аудитын албаны даргаар томилсугай.

Хоёр. О.Алтантуяагийн үндсэн цалинг ТЗ-9-1 шатлалаар 691610 /зургаан зуун ерэн нэгэн мянга зургаан зуун арван/ төгрөгөөр тооцож олгохыг Санхүүгийн хяналт, аудитын албаны нягтлан бодогч /Б.Ариунаа/-д зөвшөөрсүгэй

Гурав. Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг О.Алтантуяад үүрэг болгосугай.

Дөрөв. О.Алтантуяад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА